ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ХОА-2024/01/НА-СТА-ТЕЗ


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Ховд хот<br>2024 он | Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар<br>Утас: 99047408 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn<br>Аудитын менежер: А.Цэцэгсүрэн<br>Утас: 99013699 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Д.Нарантуул<br>Утас:99019800 Цахим хаяг: narantuuld@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Э.БОЛОРМАА ТАНАА

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2024.04.22 № 1/136
танай 2024.04.03-ны № 1/631 -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Ховд аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Ховд аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Ховд аймгийн ТЕЗ-ийн нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 78,841.3 сая, татварын орлого 20,724.4 сая, татварын бус орлого 258.7 сая төгрөгөөр тус тус өссөн, Орон нутгийн хөгжлийн сан, Орон нутгийн хөрөнгө оруулалт, Засаг дарга дансны  хөрөнгөөр хийгдэж буй төсөл хөтөлбөр, арга хэмжээнүүдийг гэрээнд заасан хугацаанд дуусгаагүйгээс авлага данс өмнөх оноос 5,699.9 сая төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Ховд аймаг нь 2023 онд тоон гарын үсэг олголт улсын дундаж 41 хувьтай, манай аймаг 76.6 хувьтай, эрүүл мэндийн эрт илрүүлгийн үзлэг оношилгоонд хамрагдалтаар улсын дундаж 37.5 хувьтай, манай аймаг 47.6 хувьтай, Иргэдэд газар олголтоор сүүлийн 1 жилийн хугацаанд 4759 хүнд газар олгогдож өмнөх онуудаас  23.3 дахин их өссөн зэрэг үзүүлэлттэй байна

**Аудитын гол асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй, хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн дугаар 14/03 тоот тоот тогтоолоор Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2023 оны зорилтуудын хэрэгжилт, бүтээн байгуулалтын бодлогын ажлын үр дүнг 90.7 хувийн биелэлттэй гэж үнэлэгджээ.

ТЕЗ-д “Алсын хараа-2050” “Шинэ сэргэлтийн бодлогын”-ын Хот хөдөөгийн сэргэлтийн хүрээнд иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх, ажлын байр шинээр бий болгох, Төрийн албан хаагчдын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, шилэн цахим үйлчилгээг өргөжүүлэх, төрийн үйлчилгээний чанар хүртээмж, шуурхай байдлыг шинэ шатанд гарган ажиллахыг даалгажээ.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.БОЛДБААТАР

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан (мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | 35,356,401.5 | 71,858,785.4 |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 18,842,112.5 | 46,048,314.6 |
| **33** | **АВЛАГА** | 9,715,813.8 | 17,808,218.9 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | 3,528,927.5 | 4,248,056.4 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 2,770,070.0 | 3,162,308.6 |
| **36** | **НӨӨЦИЙН БАРАА** | 499,477.7 | 591,886.8 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | 105,991,040.1 | 148,329,999.4 |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 105,991,040.1 | 148,329,999.4 |
| **39200** | **Биет хөрөнгө** | 96,605,922.8 | 119,917,942.9 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | 9,380,117.3 | 28,407,056.5 |
| **39400** | **Бусад хөрөнгө /ТӨҮГ/** | 5,000.0 | 5,000.0 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | 141,347,441.6 | 220,188,784.8 |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | 5,217,752.1 | 11,162,984.2 |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 5,202,752.1 | 11,147,984.2 |
| **41300** | **Өглөг** | 1,209,998.1 | 3,659,538.3 |
| **41400** | **Урьдчилж орсон орлого** | 3,992,754.0 | 7,488,445.9 |
| **42** | **УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 15,000.0 | 15,000.0 |
| **42200** | **Урт хугацаат зээл** | 15,000.0 | 15,000.0 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | 136,129,689.5 | 209,025,800.6 |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 136,129,689.5 | 209,025,800.6 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 32,407,922.1 | 32,378,654.1 |
| 51101 | Өмч /төрийн/ /ТӨҮГ/ | 12,318,367.6 | 12,318,367.6 |
| 51106 | Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/ | 9,245,693.4 | 40,218,701.6 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | 71,391,060.9 | 113,409,471.0 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 10,766,645.4 | 10,700,606.2 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | 141,347,441.6 | 220,188,784.8 |

### 2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | 149,405,716.7 | 148,123,275.4 |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | 28,509,693.4 | 49,234,061.2 |
| **110** | **Орлогын албан татвар** | 23,148,448.8 | 42,631,172.0 |
| **1100** | **Хувь хүний орлогын албан татвар** | 13,426,349.6 | 18,163,318.2 |
| **1101** | **Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт** | (728,584.7) | (881,171.7) |
| **1103** | **ААН-ын орлогын албан татвар** | 10,450,683.8 | 25,349,025.5 |
| **113** | **Хөрөнгийн албан татвар** | 2,041,441.2 | 2,260,017.2 |
| **118** | **Бусад татвар, төлбөр, хураамж** | 3,319,803.4 | 4,342,872.0 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | 39,064,356.9 | 63,553,305.1 |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 21,262,652.6 | 31,884,579.7 |
| **121** | **Хөрөнгийн орлого** | 116,872.4 | 327,163.3 |
| **123** | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | 17,684,831.9 | 31,341,562.1 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | 81,831,666.4 | 35,335,909.2 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | 118,185,706.5 | 73,489,874.0 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 118,185,706.5 | 72,392,048.9 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 59,903,713.9 | 70,528,767.4 |

| | | | |
|---|---|---|---|
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 10,253,697.4 | 12,813,894.9 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 1,221,602.9 | 1,596,361.8 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 10,459,417.9 | 3,040,842.9 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 17,662,451.0 | 20,921,317.4 |
| 2105 | Нормативт зардал | 199,351.8 | 221,747.6 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 188,981.2 | 139,853.2 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 145,056.4 | 282,222.1 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,352,882.5 | 15,655,853.8 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 17,420,272.8 | 15,856,673.8 |
| 212 | ТАТААС | 91,434.4 | 134,484.7 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 58,190,558.2 | 1,728,796.9 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | - | 1,097,825.1 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 31,220,010.2 | 74,633,401.5 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 150,047,171.1 | 32,018,502.3 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | (118,827,160.9) | 42,614,899.2 |

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан (мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 146,564,573.8 | 136,311,978.3 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 28,509,693.4 | 49,234,061.2 |
| 110 | Орлогын албан татвар | 23,148,448.8 | 42,631,172.0 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 13,426,349.6 | 18,163,318.2 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | (728,584.7) | (881,171.7) |
| 1103 | ААН-ын орлогын албан татвар | 10,450,683.8 | 25,349,025.5 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 2,041,441.2 | 2,260,017.2 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 3,319,803.4 | 4,342,872.0 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 498,344.3 | 1,393,757.4 |
| 1181 | Газрын төлбөр | 1,118,010.6 | 1,392,568.2 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 1,703,448.5 | 1,556,546.4 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 34,167,298.4 | 51,134,040.4 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 16,365,594.1 | 19,465,315.1 |
| 121 | Хөрөнгийн орлого | 116,872.4 | 327,163.3 |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 17,684,831.9 | 31,341,562.1 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 83,887,582.0 | 35,943,876.7 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 102,146,807.4 | 51,459,434.3 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 102,146,807.4 | 51,459,434.3 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 40,317,488.8 | 49,573,417.0 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 11,825,616.3 | 15,030,660.8 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 1,667,098.6 | 2,143,510.0 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 11,139,087.6 | 3,781,244.5 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 2,046,522.0 | 3,006,419.2 |
| 2105 | Нормативд зардал | 174,922.7 | 220,986.4 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 221,573.0 | 129,984.6 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 140,898.6 | 284,713.8 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,033,478.6 | 16,695,733.7 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,068,291.4 | 8,280,164.1 |
| 212 | ТАТААС | 87,684.4 | 134,484.7 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 61,741,634.2 | 1,751,532.6 |

| | | | |
|---|---|---|---|
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | 44,417,766.4 | 84,852,544.0 |
| **IV** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)** | - | 1,547,400.0 |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | 38,805,847.6 | 60,134,667.8 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | 38,805,847.6 | 60,134,667.8 |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 38,805,847.6 | 60,134,667.8 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | (38,805,847.6) | (58,587,267.8) |
| **VII** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН** | (1,552,919.8) | 940,925.8 |
| **14** | **Бусад эх үүсвэр** | 1,040,000.0 | 1,948,249.7 |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | 2,592,919.8 | 1,007,323.8 |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | 4,058,999.0 | 27,206,202.0 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 14,783,113.5 | 18,842,112.5 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 18,842,112.5 | 46,048,314.6 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (мянган төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **94,051,963.4** | **54,393,817.0** | **99,192,988.4** | **247,638,768.8** |
| **2** | **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт** | **(48,241,264.8)** | **(43,618,063.4)** | **91,025,233.4** | **(834,094.8)** |
| **3** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **45,810,698.6** | **10,775,753.7** | **190,218,221.8** | **246,804,674.1** |
| **4** | **Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт** | **-** | **(9,108.2)** | **-** | **(9,108.2)** |
| **5** | **Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт** | **8,161,284.5** | **-** | **-** | **8,161,284.5** |
| **6** | **Тайлант үеийн үр дүн** | **-** | **-** | **(118,827,160.9)** | **(118,827,160.9)** |
| **7** | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **53,971,983.1** | **10,766,645.5** | **71,391,060.9** | **136,129,689.5** |
| **8** | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **53,971,983.1** | **10,766,645.5** | **71,391,060.9** | **136,129,689.5** |
| 9 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | (596,489.0) | (596,489.0) |
| **10** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **53,971,983.1** | **10,766,645.5** | **70,794,571.8** | **135,533,200.4** |
| 11 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | - | (66,039.2) | - | (66,039.2) |
| 12 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 30,943,740.2 | - | - | 30,943,740.2 |
| 13 | Тайлант үеийн үр дүн | - | - | 42,614,899.2 | 42,614,899.2 |
| **14** | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **84,915,723.3** | **10,700,606.2** | **113,409,471.0** | **209,025,800.6** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | хувь |
|---|---|---|---|---|

| | | | | |
|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **82,500,365.8** | **68,508,521.2** | 83.0 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **40,079,985.2** | **36,369,849.7** | 90.7 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **38,227,963.2** | **34,575,956.8** | 90.4 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **12,983,152.7** | **12,717,972.7** | 98.0 |
| 210101 | Үндсэн цалин | 6,997,274.5 | 7,023,248.9 | 100.4 |
| 210102 | Нэмэгдэл | 4,165,605.7 | 3,805,302.7 | 91.4 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 80,187.3 | 99,473.5 | 124.1 |
| 210104 | Урамшуулал | 331,679.2 | 671,256.9 | 202.4 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 1,408,406.0 | 1,118,690.7 | 79.4 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **1,621,984.4** | **1,578,988.9** | 97.3 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 1,102,170.5 | 1,086,005.2 | 98.5 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 130,389.0 | 119,287.3 | 91.5 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 103,363.6 | 97,780.5 | 94.6 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 26,444.7 | 28,185.0 | 106.6 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 259,616.6 | 247,730.9 | 95.4 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **12,782,412.2** | **12,001,728.2** | 93.9 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,031,444.5 | 960,847.5 | 93.2 |
| 210302 | Түлш, халаалт | 10,769,510.3 | 10,112,763.4 | 93.9 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 981,457.4 | 928,117.2 | 94.6 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **700,372.9** | **694,029.1** | 99.1 |
| 210401 | Бичиг хэрэг | 91,144.1 | 91,361.4 | 100.2 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 493,120.1 | 491,798.0 | 99.7 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 97,518.4 | 92,364.7 | 94.7 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,572.4 | 1,493.1 | 95.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 17,017.9 | 17,011.9 | 100 |
| **2105** | **Нормативд зардал** | **221,185.3** | **220,986.4** | 99.9 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 136,705.0 | 136,705.0 | 100 |
| 210502 | Хоол, хүнс | 44,885.0 | 44,885.0 | 100 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 39,595.3 | 39,396.4 | 99.5 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **488,260.6** | **483,568.7** | 99.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 9,920.7 | 9,911.1 | 99.9 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 5,350.7 | 5,076.1 | 94.9 |
| 210604 | Урсгал засвар | 472,989.2 | 468,581.5 | 99.1 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **255,866.6** | **247,145.8** | 96.6 |
| 210702 | Дотоод албан томилолт | 255,866.6 | 247,145.8 | 96.6 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **3,292,568.7** | **2,972,816.7** | 90.3 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,222,149.2 | 2,911,341.6 | 90.4 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 8,930.9 | 3,260.0 | 36.5 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 7,285.1 | 6,649.8 | 91.3 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 4,955.5 | 4,081.5 | 82.4 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 779.7 | 552.1 | 70.8 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 39,600.9 | 38,614.4 | 97.5 |
| 210807 | Газрын төлбөр | 8,611.1 | 8,070.8 | 93.7 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 256.3 | 246.5 | 96.2 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **5,882,159.8** | **3,658,720.2** | 62.2 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,776,126.2 | 3,553,339.1 | 61.5 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 106,033.6 | 105,381.1 | 99.4 |
| **212** | **ТАТААС** | **150,320.0** | **134,484.7** | 89.5 |
| **2121** | **Төрийн өмчит байгууллагад олгох татаас** | **55,320.0** | **55,320.0** | 100 |
| 212101 | Төрийн өмчит байгууллагад олгох татаас | 55,320.0 | 55,320.0 | 100 |
| **2122** | **Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас** | **95,000.0** | **79,164.7** | 83.3 |
| 212201 | Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | 95,000.0 | 79,164.7 | 83.3 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,701,702.0** | **1,659,408.2** | 97.5 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **1,701,702.0** | **1,659,408.2** | 97.5 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 1,211,045.0 | 1,198,845.0 | 99.0 |
| 213204 | Ажил олгогчоос олгох  бусад тэтгэмж, урамшуулал | 12,552.9 | 12,552.9 | 100 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 26,000.0 | - | - |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 373,529.9 | 373,529.9 | 100 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 78,574.2 | 74,480.4 | 94.8 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **40,475,296.6** | **31,131,347.7** | 76.9 |
| 220001 | Барилга байгууламж | 17,590,389.1 | 12,547,482.4 | 71.3 |
| 221001 | Их засвар | 10,756,420.4 | 8,534,651.7 | 79.3 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 4,358,424.7 | 3,688,774.8 | 84.6 |
| 223001 | Бусад хөрөнгө | 7,770,062.4 | 6,360,438.9 | 81.9 |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | **1,945,084.0** | **1,007,323.8** | 51.8 |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 1,945,084.0 | 1,007,323.8 | 51.8 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **82,500,365.8** | **70,378,555.3** | 85.3 |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **68,933,068.0** | **61,272,712.4** | 88.9 |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 49,677,669.3 | 42,221,589.2 | 85.0 |
| 320002 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 19,255,398.7 | 19,051,123.2 | 98.9 |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **13,567,297.8** | **9,105,842.9** | 67.1 |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 71,810.0 | 66,024.0 | 91.9 |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 9,219,428.1 | 9,039,818.9 | 98.1 |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 4,276,059.7 | - | |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 4,604,146.9 | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 6,429,967.6 | |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **1,551.0** | **1,551.0** | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **43.0** | **43.0** | |
| 610001 | Төсвийн байгууллага | 43.0 | 43.0 | |
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | - | - | |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **754.0** | **754.0** | |
| 620001 | Удирдах ажилтан | 171.0 | 171.0 | |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 307.0 | 308.0 | |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 106.0 | 106.0 | |
| 620004 | Гэрээт ажилтан | 170.0 | 169.0 | |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **754.0** | **754.0** | |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 298.0 | 300.0 | |
| 650002 | Төрийн тусгай албан хаагч (ТТ) | 4.0 | 4.0 | |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 222.0 | 220.0 | |
| 650010 | Гэрээт ажилтан | 82.0 | 82.0 | |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 148.0 | 148.0 | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 66 | НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ | 16.0 | 16.0 | |
| 660001 | Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч | 16.0 | 16.0 | |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | өмнөх он | тайлант он |
|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **7,665,337.9** | **12,171,230.4** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **7,639,752.1** | **11,290,384.7** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **7,134,527.4** | **9,786,771.1** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **433,534.8** | **28,490.4** |
| 210101 | Үндсэн цалин | 3,441.7 | 5,173.2 |
| 210104 | Урамшуулал | 413,469.7 | - |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 16,623.4 | 23,317.2 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | | **602.5** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 602.5 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **645,752.3** | **606,266.2** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,292.2 | 8,683.4 |
| 210302 | Түлш, халаалт | 640,460.1 | 597,582.8 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **28,518.9** | **59,583.5** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,514.0 | 455.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 14,412.0 | 55,982.1 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 300.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,203.7 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 11,389.2 | 2,846.4 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **12,936.6** | **6,728.7** |
| 210604 | Урсгал засвар | 12,936.6 | 6,728.7 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **35,245.8** | **20,442.9** |
| 210702 | Дотоод албан томилолт | 35,245.8 | 20,442.9 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **612,074.1** | **3,145,747.3** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 612,074.1 | 3,145,747.3 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **5,366,464.9** | **5,918,909.5** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,346,009.9 | 5,911,848.5 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 20,455.0 | 7,061.0 |
| **212** | **ТАТААС** | **35,000.0** | **-** |
| **2122** | **Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас** | **35,000.0** | **-** |
| 212201 | Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | 35,000.0 | - |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **470,224.7** | **1,503,613.7** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **3,850.0** | **33,957.0** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,850.0 | 33,957.0 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **466,374.7** | **1,469,656.7** |
| 213405 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 466,195.7 | 1,469,656.7 |
| 213503 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | 179.1 | - |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **25,585.8** | **880,845.7** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **25,585.8** | **880,845.7** |
| 220001 | Барилга байгууламж | 20,585.8 | 634,662.6 |
| 221001 | Их засвар | | 52,942.4 |
| 222001 | Тоног төхөөрөмж | | 120,599.8 |
| 223001 | Бусад хөрөнгө | | 3,294.8 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | | 69,346.1 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **7,665,158.9** | **12,171,230.4** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **7,665,158.9** | **12,171,230.4** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 793,017.6 | 375,419.6 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,385,958.1 | 7,640,228.0 |

| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,542,493.0 | 1,639,812.2 |
|---|---|---|---|
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 943,690.2 | 2,515,770.7 |
| **III** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | **(179.1)** | **-** |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 179.1 | - |

## ГУРАВ . ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН АУДИТЫН ДҮНГИЙН ТАЛААР

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 45 төсвийн байгууллага, 17 төсвийн төвлөрүүлэн захирагч, 9 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 35 тусгай сан, нийт 106 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 106 байгууллага аудитад хамрагдаж, Үенч-Эрчим хүч, Чандмань БИТ, Үенч Мөнх ундарга баялаг, Эв эеийн хүч ОНӨААТҮГ-ууд нь үйл ажиллагаа явуулдаггүй тул хамрагдаагүй байна.

Тайлант онд Аймгийн ИТХ-ын 8/04 дугаар тогтоолоор Алтай, Зэрэг, Мянгад сумын Шим ус ОНӨААТҮГ-ууд аймгийн Шим Ус ОНӨААТҮГ-т нэгтгэсэн, Дарви ТҮК, Эрдэнэбүрэн Хар ус ОНӨААТҮГ шинээр нээгдэж аудитад хамрагдаагүй ТЕЗ-ийн тайланд санхүүгийн тайлангаа нэгтгүүлсэн байна. *Хүснэгт 1. Аудитад хамрагдсан байгууллагын аудитын дүгнэлтийн судалгаа*

| д/д | Төсвийн захирагчийн ангилал | дүгнэлтийн дүн | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | зөрчилгүй | Хязгаарлалт тай | сөрөг | түүвэрт |
| 1 | ТШЗ | 80 | 2 | 2 | 1 | 75 |
| 2 | ТТЗ | 17 | 9 | 8 | | |
| 3 | ОНӨААН | 9 | 3 | | 1 | 5 |
| | **Дүн** | **106** | **14** | **10** | **2** | **80** |

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас 80 байгууллагыг түүвэрт хамруулж, 26 байгууллагад дүгнэлт хүргүүллээ. Үүнд: *“Зөрчилгүй”*-14, *“Хязгаарлалттай”*-10 /Алтай, Буянт, Дарви, Манхан, Мөст, Зэрэг, Үенч, Эрдэнэбүрэн сумдын ТТЗ, аймгийн ИТХ/, *“сөрөг”* -2 / аймгийн ЗДТГ, Шинэ Ховд баруун бүсийн хөгжлийн корпорац / санал дүгнэлт өгсөн байна.

*Хүснэгт 2. Аудитад хамрагдсан харьяа байгууллагын судалгаа алдаа, зөрчил* */сая.төгрөг/*

| д/д | Төсвийн захирагчийн ангилал | Нийт алдаа зөрчлийн дүн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | залруулга | | төлбөрийн акт | | албан шаардлага | | зөвлөмж | |
| | | тоо | дүн | тоо | дүн | тоо | дүн | тоо | дүн | тоо | дүн |
| 1 | ТШЗ | 209 | 9,509.4 | 80 | 5,704.0 | 26 | 102.3 | 12 | 592.8 | 91 | 3,110.3 |
| 2 | ТТЗ | 55 | 2,925.6 | 17 | 829.2 | 3 | 100.4 | 5 | 726.8 | 30 | 1,269.2 |
| 3 | ОНӨААН | 28 | 12,820.9 | 6 | 11,926.1 | 4 | 89.2 | 1 | 384.0 | 17 | 421.6 |
| | **Дүн** | **292** | **25,255.9** | **103** | **18,459.3** | **33** | **291.9** | **18** | **1,703.6** | **138** | **4,801.1** |

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 25,255.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 18,459.3 сая төгрөгийн 103 алдааг залруулж, 291.9 сая төгрөгийн зөрчилд 33 төлбөрийн акт тогтоож, 1,703.6 сая төгрөгийн зөрчилд 18 албан шаардлага, 4,801.1 сая төгрөгийн алдаа, зөрчилд 138 зөвлөмж өглөө.

## ДӨРӨВ: АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ :

Аудитаар нийт 373.2 сая төгрөгийн алдаа[1], зөрчил илэрснээс 48.3 сая төгрөгийн алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалтын дагуу санхүүгийн тайланд залрууллаа. Үүнд:

- *Барьцаа дансны хөрөнгөнөөс өвс тэжээлийн нөөц бий болгох зорилгоор 48.3 сая төгрөгийг аймгийн ЗДТГ руу шилжүүлснийг авлагаар бүртгээгүй*

Аудитаар нийт 324.9 сая төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 41.3 сая төгрөгийн төлбөрийн акт, 10.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 273.6 сая төгрөгийн 5 зөвлөмж хүргүүллээ.

**4.1 Төлбөрийн акт**

Илрүүлэлт: Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг санхүүжүүлээд хэмнэгдсэн 41.4 сая төгрөгийг сангийн дансанд буцаан төвлөрүүлээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*”, 18.1-д *“Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”* гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аймгийн ОНХС-гийн 100160052400 тоот дансанд төвлөрүүлэх

**4Албан шаардлага**

Засаг дарга данснаас Наурызын баярын үйл ажиллагаанд 10.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон, зарцуулалтын тайлангүй, бусад анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”,13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэсэн заалтуудтай нийцээгүй, “Тохиолдсон байх”, “Иж бүрэн байх”, “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***Шийдвэрлэсэн:*** Албан шаардлага өгөх

**4.3. Зөвлөмж**

**4.3.1 Үндсэн хөрөнгө данстай холбоотой асуудал:**

***Илрүүлэлт:*** 1. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд худалдан авсан 20 нэр төрлийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 36 дугаар тогтоолоор “Иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх” төслийн хүрээнд Швейцарын хөгжлийн агентлагийн буцалтгүй тусламжаар нийлүүлсэн УАЗ-2202695 паркийн тусгай тоноглолтой тээврийн хэрэгсэл, бусад тоног төхөөрөмжийг тухайн үед данс бүртгэлд тусгасан эсэх нь тодорхой бус, бодитоор оршин байхгүй,

**4.3.2** Жаргалант сумын ЗДТГ-ын данс бүртгэлд байгаа 120.0 сая төгрөгийн өртөгтэй 3 ширхэг нийтийн тээврийн автобус ард иргэдэд үйлчилдэггүй, хувь иргэнд эзэмшүүлэх гэрээ байгуулсан эсэх нь тодорхой бус, Дуут, Дөргөн сумын ЗДТГазар аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр багийн дарга нартын албан хэрэгцээнд зориулан худалдан авсан 1.2 сая төгрөгийн өртөгтэй мотоцикл данс бүртгэлд тусгаагүй, Мөст сумын багийн дарга нарт олгосон мотоцикл бодитоор оршин байхгүй зэрэг нийт 13.6 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоол Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 4 дүгээр зүйлийн 4.1-д

---

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

“Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний болон хандив, бэлэглэл, тусламжийн хүрээнд бий болсон хөрөнгийг санхүүжилтийн гүйцэтгэлээр эрх бүхий байгууллагын албан бичиг, тооцоо гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт, хөрөнгө тус бүрийн үнийн задаргааг харгалзан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журамд заасны дагуу Монгол хэлээр, зөв оновчтой нэршлээр данс бүртгэлд тусгана”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг нягтлан бодох бүртгэлд заавал бүртгэнэ" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

**Өгсөн зөвлөмж**: Хөрөнгө оруулалтаар хийгдсэн хөрөнгийг данс бүртгэлд бүрэн тусгаж, хөрөнгийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулан ажиллах

### *4.3.3 Авлагын данстай холбоотой асуудал*

**Илрүүлэлт:** Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд 29 аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн ажлыг хүлээн авах хугацаа болоогүйтэй холбоотой 247.2 сая төгрөгийн авлагыг данс бүртгэлд тусгаагүй,

**4.3.4** Тайлант онд Байгаль орчин аялал жуулчлалын газар, аймгийн ИТХ, ЗДТГ-аас хуулийн дагуу олгодог тэтгэвэр тэтгэмжийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн, Орон нутгийн хөгжлийн сан, Орон нутгийн хөрөнгө оруулалт, Засаг дарга дансны хөрөнгөөр хийгдэж буй төсөл хөтөлбөрүүдийг гэрээний хугацаанд дуусгаагүйгээс авлага өмнөх оноос нэмэгдсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т “Нягтлан бодох бүртгэлд бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал бүртгэнэ”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

***Өгсөн зөвлөмж:*** Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд гарсан зардлыг 2024 оны хагас жилийн санхүүгийн тайланд авлагаар хүлээн зөвшөөрч залруулан, гэрээний үүргийн хэрэгжилтэд ажлын хэсэг томилон хяналт хэрэгжүүлэх, авлагыг бууруулан ажиллах

### *4.3.5 Зардал данстай холбоотой асуудал*

***Илрүүлэлт:*** Аймгийн ГХБХБГ-ийн чиг үүрэгтэй давхардуулан орон нутагт Барилгын захиалагчийн алба байгуулах болон аймгийн ЗДТГ-т гэрээгээр хяналтын инженер ажиллуулсан 12.7 сая төгрөгийн цалингийн зардал зарцуулсан, Мянган-Угалзат ОНӨААТҮГ нь өр төлбөрийг барагдуулан хуваарь гаргаж ажиллаагүй, өр төлбөрийг өмнөх оноос нэмэгдүүлж, төсвийг үр дүнтэй зарцуулаагүй, дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй зөрчлүүд илэрлээ.

Энэ нь Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 83 дугаар "Барилгын захиалагчийн хяналтын талаар авах зарим арга хэмжээний тухай" тушаалын 2.1.3-д "Барилгын тухай хууль, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Барилгын ажлын захиалагчийн дүрэм", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-д “хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх;” гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

***Өгсөн зөвлөмж:*** Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйл, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 83 дугаар тушаалуудыг хэрэгжүүлэн ажиллах

**Тав. Аудитаар илэрсэн буюу илэрхийллийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл** ( мян.төгрөг)

| байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс Залруулсан | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ТЕЗ / барьцаа данс/ | 1 | 48,249.6 | | | 1 | 48,249.6 | 1 | 48,249.6 | | |
| Дүн | 1 | 48,249.6 | - | - | 1 | 48,249.6 | 1 | 48,249.6 | - | - |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

( мян.төгрөг)

| байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Аймгийн ОНХСан | 1 | 41,375.0 | 1 | 41,375.0 | | | | |
| Засаг дарга | 1 | 10,000.0 | | | 1 | 10,000.0 | | |
| Аймгийн ОНХСан | 1 | 247,248.0 | | | | | 1 | 247,248.0 |
| Жаргалант, Дуут, Дөргөн, Мөст сумын ЗДТГазар | 1 | 13,600.0 | | | | | 1 | 13,600.0 |
| Аймгийн ЗДТГазар | 1 | | | | | | 1 | |
| Засаг дарга | 1 | 12,741.0 | | | | | 1 | 12,741.0 |
| Аймгийн ИТХ, ЗДТГ, БОАЖГазар, ОНХО, ОНХС, Засаг дарга | 1 | - | | | | | 1 | |
| **Дүн** | **7** | **324,964.0** | **1** | **41,375.0** | **1** | **10,000.0** | **5** | **273,589.0** |

## ЗУРГАА. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо: Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр: Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Санал дүгнэлтийн хэлбэр: Зөрчилгүй | Хязгаарлалт тай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 45 | 5 | 40 | | 2 | 2 | 1 | |
| 2 | ОНӨААТҮГ | 9 | 4 | 5 | | 3 | | 1 | |
| 3 | ЗГТС | 35 | | 35 | | | | | |
| 4 | ТТЗ | 17 | 17 | | | 9 | 8 | | |
| 5 | ТЕЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| | **НИЙТ** | **107** | **27** | **80** | **-** | **15** | **10** | **2** | **-** |